

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
1.1	Эцэг/эхийн нэр: Амаржаргал Нэр: Энхбат
	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал Төсвийн тогтвортой байдлын завлалийн гишүүн
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. <u>Тийм</u> Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. <u>Үгүй.</u>
1.4	Хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа эсэх: -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх; <u>1. Төрийн бодлогын ухааны магистр 2000, Япон Улсын Сайтама Их сургууль GRIPS –IMF External debt management and problem of Mongolia, Монгол Улсын Гадаад өрийн удирдлага, зарим асуудлууд.</u> <u>2. Бизнесийн удирдлагын ухааны доктор (PhD). 2010. МУИС Диссертацийн ажлын сэдэв “Монгол Улсын Санхүүгийн хөтөлбөр боловсруулах арга зүйн асуудлууд”</u> -сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх; <u>Аль нэгийн Намын гишүүнчлэл байхгүй, улс төрийн үйл ажиллагаанд оролцож байгаагүй.</u> -зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх; <u>А.Энхбат миний бие зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өр байхгүй.</u> -хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх; <u>Хувь хүний ёс зүйн болон нэр хүнд нөлөөлөхгүй харшлахгүй.</u> -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх, эсхүл эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх. Үүнд дараах мэдээллийг бичнэ. <ul style="list-style-type: none">албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа (эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно);

	<ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн тэнхимд дэд профессор, ахлах багш, багш, 50% багш, Монгол Улсын Их Сургууль, Бизнесийн сургууль, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-4, МУИС хичээлийн 4-р байр, /2005-өнөөдрийг хүртэл/ нийт 18 жил 2. Үндэсний Аудитын Газар, Монгол Улсын Ерөнхий аудиторын зөвлөх, Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160, Ажилласан жил 2 жил /2017-2019 он/ 3. Швейцарийн хөгжлийн агентлаг, АНУ-ын Азийн сан, “Иргэдийн оролцоо” төслийн Үндэсний зөвлөх 2 жил /2013-2015 он/ 4. Сангийн яам, Төсвийн бодлогын газар Дэлхийн банкны Олон талыг хамарсан техник туслалцааны төсөл, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, Татварын ерөнхий газар, Үндэсний зөвлөх. 3 жил /2011-2014 он/ 5. Сангийн яам, Төсвийн бодлогын газар, Дэлхийн банкны Эдийн засгийн засгийн чадавхийг бэхжүүлэх төслийн зөвлөх, С.Данзангийн гудамж Засгийн газрын 2-р байр УБ 15160 Үндэсний зөвлөх 4 жил /2007-2011 он/ 6. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв байгууллагуудын хэлтэс, Засгийн газрын санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан референт. Төрийн ордон 5 жил /2002-2007 он/ 7. Санхүү эдийн засгийн яам, Гадаадын зээл, тусламжийн бодлого, зохицуулалтын газар, ахлах мэргэжилтэн 2 жил /2000-2002 он/ 8. Сангийн яам Төсвийн бодлогын газар, Төрийн сангийн хэлтэс, хэлтсийн дарга, албаны дарга, мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн 4 жил /1994-1998 он/ <ul style="list-style-type: none"> • эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлснийг нотлох баримт бичиг, нийтлэлийн хуулбар. <ol style="list-style-type: none"> 1. Бүтээлийн жагсаалтийг хавсралтаар харуулав. 2. Олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн материалыг хавсаргав.
1.5	<p>Мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар Хүсэлт гарагчийг эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр өндөр мэдлэг, ур чадвартайг нотлох онцлох 10 үйл ажиллагааг жагсаан (хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар) бичнэ. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1) Монгол Улсын Их Сургууль, Бизнесийн сургууль, Санхүүгийн тэнхим, сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа. 2005-2023 2) Төрийн аудитын үйл ажиллагаа YAГ. Монгол Улсын Ерөнхий аудиторын зөвлөх 2017-2019 3) Шилэн дансны тухай хуулийн төслийн эх баригч, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн 2014, Монгол Улсын ЕТГ 4) Өрийн удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүн 2014, Сангийн яам 5) Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүн 2014, Сангийн яам, ЕТГ 6) Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүн 2009, Сангийн яам, Дэлхийн банкны төсөл 7) Төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүн, ОУВС-нгийн Хуулийн газартай хамтран боловсруулсан. Сангийн яам, Дэлхийн банк, ОУВС төсөл 2008-2010 8) Дунд хугацааны төсвийн төлөвлөлт Сангийн яам, Дэлхийн банкны төсөл 2007-2009 он. 9) Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн талаархи Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд. Сангийн яам, Дэлхийн банкны төсөл. 10) Боловсрол, мэдлэг <ol style="list-style-type: none"> 1. МУИС-санхүүч, эдийн засагч /бакалвр 1990-1994/ Дипломын сэдэв. Улсын төсвийн төлөвлөлтийн арга зүй 2. ОУВС-Японы Засгийн газар Япон Улсын Сайтама Их сургууль GRIPS /Төрийн бодлогын ухааны магистр 1998-2000/ Дипломын сэдэв. Монгол Улсын Гадаад өрийн удирдлага болон зарим асуудлууд.

	<p>3. МУИС Бизнесийн удирдлагын ухааны доктор (PhD). 2003-2010. Диссертацийн ажлын сэдэв. Монгол Улсын Санхүүгийн хөтөлбөр боловсруулах арга зүйн асуудал.</p>
<p>1.6</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татвар гэх мэт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ. -Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ.</p> <p><u>Монголын Санхүүчдийн холбоо 2005</u></p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байгаа албан тушаалын нэр, огноог бичнэ. <u>Монголын Санхүүчдийн холбооны гишүүн</u></p>
<p>1.7</p>	<p>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл -Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1) https://www.num.edu.mn/Staff/f519ef5d-1ad0-44bf-90eb-f7545816bdc3/Publications 2) Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь 2022 https://internom.mn/%D0%B1%D0%B0%D1%80%D0%B0%D0%B0/9789919514679-%D0%B7%D0%B0%D1%85%D0%B8%D1%80%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD%D1%8B-%D1%88%D0%B8%D0%BD%D0%B6%D0%BB%D1%8D%D1%85-%D1%83%D1%85%D0%B0%D0%B0%D0%BD%D1%8B-%D0%BD%D1%8D%D1%80-%D1%82%D0%BE%D0%BC%D1%8C%D1%91%D0%BE%D0%BD%D1%8B-%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B1%D0%B0%D1%80-%D1%82%D0%BE%D0%BB%D1%8C 3) Нийтийн салбарын стратегийн удирдлага /2021/ Жойс - Нийтийн салбарын стратегийн удирдлага - МУИС (yumpu.com) 4) Төрийн /нийтийн/ төсөв, санхүүгийн хяналт шалгалт: онол, практик, арга зүй, тогтолцоо, эрх зүйн орчин /2022/ https://www.esan.mn/p/mergejiin-nom/sanhuu-ediin-zasag/toerijn-niitijn-toesoev-sanhueuegijn-hyanalt-shalgalt 5) Төрийн албан хаагчийн ширээний ном-4 6) "Төсвийн орлогоос Ирээдүйн өв санд хөрөнгө хуримтлуулах болон Засгийн газрын өрийг барагдуулах харьцуулсан судалгаа" Мөнгө санхүү, vol. 2019/02 (06), no. 2523-417X, pp. 85-97, 2019-12-6. 7) "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, сайжруулах арга зам" Бизнес ба инноваци, vol. 2019/06 (15), no. 2616-3845, pp. 51-78, 2019-6-1. https://journal.num.edu.mn/BusinessAndInnovation/article/view/2357 8) "Орон нутгийн хөгжлийн сангийн өнөөгийн байдал, сайжруулах арга зам" Мөнгө санхүү, vol. 2019/01/(04), no. 2523-417X, pp. 22-41, 2019-5-30 . 9) Төрийн албан хаагчийн ширээний ном -2 10) Хөрөнгө оруулалтын төслийн зардал үр ашгийн шинжилгээний арга зүй. 2019 <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1) Төсвийн тухай хууль 2011. ОУВС-нгийн Хуулийн газартай хамтран боловсруулсан. Сангийн яам, Дэлхийн банк, ЕСТАС төсөл. ОУВС Хуулийн газрын ажлын хэсэг 2008-2010 2) Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010. ОУВС-нгийн Хуулийн газартай хамтран боловсруулсан. Сангийн яам, Дэлхийн банк, ЕСТАС төсөл. ОУВС Хуулийн газрын ажлын хэсэг 2008-2010 3) Өрийн удирдлагын тухай хууль 2015 Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Сангийн яам 4) Ирээдүйн өв сангийн тухай хууль 2015 Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Сангийн яам

	<p>5) Шилэн дансны тухай хууль 2014-2015 Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар https://dnn.mn/news/3955</p> <p>6) Жил бүрийн төсвийн тухай хууль, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлүүд, төсөв, санхүүгийн эрх зүйн актууд Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газрын тогтоолууд, Ерөнхий сайдын захирамжууд 2002-2007 он хүртлэх санхүү, эдийн засгийн холбогдолтой бүх баримт бичгүүд.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>1) БНСУ-ын Сөүл хотноо болсон “Нээлттэй засгийн түншлэлийн Ази-Номхон далайн бүс нутгийн хурал”-д Монгол Улсын Ерөнхий аудиторовын зөвлөх док. Проф. А.Энхбат илтгэл тавилаа. Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотноо 2018 оны 11 дүгээр сарын 5-6-ны өдрүүдэд болсон “Нээлттэй засгийн түншлэлийн Ази-Номхон далайн бүс нутгийн хурал”-д Монгол Улсын Ерөнхий аудиторовын зөвлөх, док. проф. А.Энхбат оролцлоо. Монгол Улсын Ерөнхий аудиторовын зөвлөх, док. проф. А.Энхбат “Иргэдийн оролцоо ба практик: Итгэлийг сайжруулах болон сайн үйлчилгээг чиглүүлэх” хэлэлцүүлэгт Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын дэргэдэх Аудитын иргэний танхимын үйл ажиллагаа болон хууль эрх зүйн шинэчлэлтийн талаар илтгэл тавьж танилцуулсан юм. https://audit.mn/archive/?p=30140</p> <p>https://www.num.edu.mn/Staff/f519ef5d-1ad0-44bf-90eb-f7545816bdc3/Publications</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p>1) http://times.mn/9o7 Судлаач юу хэлэв? -2023-11-16. УИХ-ын нэгдсэн чуулганаар Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг хэлэлцэн баталлаа. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн төслийг бараг өөрчлөлтгүй баталсан юм. Энэ төсвийн талаар мэргэжлийн хүний дүгнэлтийг та бүхэнд хүргэж байна.</p> <p>2) https://lemonpress.mn/post/opVqIvKz4KQ Төсвийн тогтворгүй хууль ба сонгуулийн жилийн төсөв 2023/11/15</p> <p>3) NTV Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн тухай 2023/11 сар</p> <p>4) NTV Нийслэлийн төсвийн төслийн талаар 2023/11 сар</p> <p>5) https://itoim.mn/article/B15iw/18621 МУИС-ийн Бизнесийн сургуулийн багш, доктор (Ph.D), дэд проф. А.Энхбаттай Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлээд буй Монгол Улсын 2020 оны төсвийн төслийн талаар</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</p>
1.8	<p>Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/</p>
	<p><u>Үгүй. E-mongolia цахим тодорхойлолт хавсаргасан.</u></p>
1.9	<p>Сахилгын шийтгэлийн талаар Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх</p>

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p> <p><u>1. Нэр дэвшсэн үндэслэл:</u></p> <p>А.Энхбат миний бие Монгол Улсын Их сургуулийн Эдийн засгийн сургуулийг 1990-1994 онд хугацаанд суралцан санхүүч-эдийн засагч мэргэжлээр, бакалавр цолтой төгссөн. ОУВС болон Япон Улсын Засгийн газрын тэгтгэлгээр Япон Улсын Сайтамагийн Их Сургуульд (GRIPS) 1998-2000 онд суралцаж, Төрийн бодлогын магистр зэрэг хамгаалсан. Монгол Улсын Их Сургуульд 2003-2010 онуудад докторантурт суралцаж, “Монгол Улсын Санхүүгийн хөтөлбөрийг боловсруулах арга зүйн асуудал” сэдвээр 2010 онд бизнесийн удирдлагын боловсролын доктор (PhD)-ын зэрэг хамгаалсан.</p> <p>Монгол Улсын Сангийн яам, Санхүү, эдийн засгийн яаманд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, албаны дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан референт, Монгол Улсын Ерөнхий аудиторын зөвлөх, Дэлхийн банк, АХБ, ШХА зэрэг олон улсын байгууллагуудад төсөв, санхүүгийн чиглэлээр Үндэсний зөвлөхийн ажил хийж байсан туршлагатай. Мөн 2005 оноос хойш өнөөдрийг хүртэл МУИС-ийн Бизнесийн сургуульд багшаар ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд миний бие өөрийн багийн хамт олонтойгоо хамт дараахь хуулийн төслүүдийг боловсруулахад оролцон УИХ-аар батлуулсан.</p> <ol style="list-style-type: none">1) Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн анхны төсөл2) Төсвийн тухай хуулийн төсөл (ОУВС-нгийн Хуулийн газрын ажилтнуудтай хамтран)3) Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсөл (ОУВС-нгийн Хуулийн газрын ажилтнуудтай хамтран)4) Монгол Улсад Дунд хугацааны төсвийг төлөвлөлтийг сайжруулах нэвтрүүлэх5) Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн төсөл6) Шилэн дансны тухай хуулийн төсөл7) Өрийн удирдлагын тухай хуулийн төсөл8) Баялгийн сангийн тухай хууль9) Шилэн дансны тухай хуулийн төслүүдийг боловсруулахад гар бие оролцон идэвхийлэн ажилласан. <p>УИХ нь 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталж, төсвийн удирдлага, тогтвортой байдлыг хангах арга хэрэгсэл, төсвийн удирдлагын</p>
-----	---

үндсэн зарчим, төсвийн тусгай шаардлагуудыг олон улсын тэргүүн туршлагад нийцүүлэн тогтоож, төсвийн тогтвортой байдлыг хангахад хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын түвшинд гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тогтоож бүрэн хуульчилсан. “**Төсвийн тогтвортой байдлын тухай хууль**” хуулийн гол зорилго, нь төсвийн хэд хэдэн тусгай шаардлагыг хуульчлан тогтоож мөрдүүлэхэд чиглэгдэж байсан. Тухайлбал: **нэгд**, Засгийн газар эрдэс баялгийн үнийн мөчлөг дагасан бус төсвийн бодлого явуулдаг байх **хоёрт**, зэс, алт зэрэг цөөн төрлийн байгалийн түүхий эд олборлолтоос төсөв хараат явж ирсэн байдлыг өөрчилж, санхүүгийн бодит боломжид суурилсан төсвийн харилцаанд шилжиж төсвийн орлогыг тэнцвэржүүлж тооцдог арга хэрэглэдэг болох, **гуравт**, эдийн засагт хямрал тохиолдсон үед түүнээс сэргийлэх үндэсний санхүүгийн тогтвортой хуримтлал бүрдүүлж ашигладаг төсвийн тогтворжуулалтын шинэ хэрэгсэлтэй болох. Өөрөөр хэлбэл **төсвийн тогтворжуулалтын санг** олон улсын сайн туршлага, жишгийг харгалзан эрдэс баялгийн түр зуурын үнийн өсөлтөөс бий болсон төлөвлөгөөт бус орлогоос бүрдүүлж хэрэглэх, **дөрөвт**, төсвийн зарлагын өсөлт, улсын өрийн хэмжээнд хуулиар тусгай хязгаарлалт тогтоох, **тавд**, улс төрийн намын сонгуулийн амлалтын оновчтой бус хүсэл сонирхолд төсвийн бодлого хөтлөгдөж, улмаар нийгмийн халамж нэрийн дор их хэмжээний бүтээмжгүй мөнгө төсвөөр дамжуулж гүйлгээнд гаргаж инфляци хөөрөгдөх, энэ нь макро эдийн эдийн засаг, санхүү-төсвийн тогтворгүй байдал бий болгох явдлаас сэргийлэхэд чиглүүлэх хуулийн орчин бий болгох шаардлагатай үзэж анх батлуулсан.

Гэсэн хэдий ч Сангийн яам, Засгийн газар, Улсын Их Хурал нь Төсвийн тогтвортой байдлыг тухай хуулинд өөрчлөлт оруулах, санал гаргах замаар хуулийн үндсэн зарчим, агуулгыг хүчгүйдүүлж ирж, улмаар энэ хууль шүдгүй арслан мэт болсон. Өөрөөр хэлбэл тус хуулинд өнгөрсөн хугацаанд УИХ нийтдээ 12 удаагийн нэмэлт өөрчлөлтүүдийг хийсэн. Сангийн яам, Засгийн газраас Төсвийн хүрээний мэдэгдлийг жилийн улсын төсвийг боловсруулахад баримтлах зарчим, төсвийн зорилтыг тодорхойлох гол удирдамж гэж бодон УИХ-аар батлуулдаг ч өнгөрсөн хугацаанд улс, төр, нийгэм эдийн засгийн нөхцөл байдлын улмаас жил бүрийн улсын төсвийн төслийг боловсруулах, ДХТХМ-ийг баримтлахгүй байхаар хуулинд өөрчлөлт оруулах замаар явж ирсэн. Улсын төсвийн төслийг хэлэлцэж, Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд тусгагдсан эдийн засгийн өсөлт, төсвийн нийт орлого, татварын орлогыг оролцуулан төсвийн нийт зарлага зэрэг үндсэн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулах, төсвийн санхүүжилтэд түр зуурын санхүү-эдийн засгийн болон гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр үүссэн төсвийн орлогын тогтворгүй эх үүсвэрийг ашиглан төсвийг тэлэх замаар Засгийн газрын зардлыг нэмэгдүүлэх шийдвэрийг УИХ байнга гаргаж ирсэн.

Өнгөрсөн хугацаанд Төсвийн тогтворгүй байдал үүссэн тохиолдолд төсвийг тогтворжуулах үндэсний санхүүгийн хуримтлал байхгүйгээс төсвийн алдагдал нэмэгдэж, нийгэм, эдийн засгийн салбарын зарлага, төсвийн хөрөнгө оруулалт зэрэг уламжлалт санхүүжилт эрс танагдаж, улмаар иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлөн, макро эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдалд хүргэж, улсын төсөв, санхүүгийн эрсдэл үүсч ирсэн.

Төсвийн хариуцлагын тухай хуулийг буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг органик Төсвийн хуулиас тусад нь гаргах практикийг 80-аад оны дунд үеэс ЭЗХАХБ-ын нэлээд олон орон, хөгжиж буй эдийн засагтай орнууд дагаж мөрдсөн.

Ийм хуулийг дагаж мөрддөг 40 орчим улс байдгийн дийлэнх нь хөгжиж буй орнууд бөгөөд манай улстай ижил төрлийн эдийн засаг багатай, ашигт малтмалын эх үүсвэрээс хамааралтай улс орнууд байдаг. Үүнтэй холбоотойгоор эдгээр улсууд төсвийн тогтвортой байдалд хэлбэлзэлтэй байдаг. Цаашилбал, ЭЗХАХБ-ын орнуудаас дор дурдсан хууль тогтоомжийн дагуу дараахь улс орнуудад бодлого боловсруулагчид болон шийдвэр гаргагчдын зүгээс төсвийн удирдлагад болгоомжтой, хариуцлагатай хандахын тулд төсвийн хариуцлагыг бэхжүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Үүнд: Их Британи (Төсвийн тогтвортой байдлын код), Австрали (Төсвийн шударга байдлын дүрэм), Шинэ Зеланд (Төсвийн хариуцлагын тухай хууль) болон Европын холбоо (Маастрихтын гэрээ).

2. Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил

Цаашид дараахь ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай.

- 1) Төсвийн тогтвортой байдлын эрх зүйн орчинг сайжруулах, Төсвийн тогтвортой байдлын зарчмуудыг Үндсэн хуулийн заалт болгон батлуулах.
- 2) Засгийн газар, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Монголбанкны явуулж байгаа макро эдийн засгийн бодлогууд болох төсвийн бодлого, мөнгөний бодлого, валютын ханшны бодлого, бүтцийн бодлогуудын хоорондын уялдаа холбоог нягтлан шалгах, засварлах, зааварчлах, удирдамжаар хангах,
- 3) Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл болон дунд хугацааны төсөв, жилийн төсвийг боловсруулахад шаардагдах үнэн зөв тооцоолсон макро эдийн засгийн загварчлалыг нэгдсэн загварчлалтай болгох.
- 4) Улс орны санхүү, эдийн засгийн төв байгууллагуудын мэдээллийн нэгдсэн дата баазтай болгох.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Амаржаргал

Өөрийн нэр: Энхбат

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

--- оОо ---